

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ
(2024 оны хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлтээр)

2024 оны 12 дугаар сарын 10Улаанбаатар хот

Д/д	Үйл ажиллагаа, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Суурь түвшин, үр дүнгийн үзүүлэлт (2020 он)	Хүрсэн түвшин, үр дүн (2024 он)	Хувь
ЕС. УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ						
Зорилго 9. Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ.						
ДАГУУЛ ХОТ						
Зорилт 9.5. Хөрөнгө оруулалтын шинэ боломж бүрдүүлж, үйлдвэрлэлийн бүс нутгийг тэлнэ.						
1	9.5.5. хот, тосгоныг холбосон хурдны тойрог зам дагуу аялал жуулчлалын цогцолборуудыг байгуулж, монгол брэндийн худалдааны төвийг нээн ажиллуулна.	2021-2025	1,300.0 Хувийн хэвшил	-	Улаанбаатар хот орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын цогцолборуудыг байгуулах зорилтын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/556 дугаар захирамжаар Налайх дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт “Плэйтийм” тогтвортой ногоон хүрээлэн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх 500,000 м.кв талбай бүхий газрын асуудлыг шийдвэрлэсэн. Төслийг “Арван Долоо Гучин Долоо Энтертайнмент” ХХК-тай гэрээ байгуулан хэрэгжүүлж, цогцолборын байгууламжийн гадна талын 5000 м урт хашаа, 2500 м урт тусгаарлах хашаа барьж, цахилгаан, цэвэр усны эх үүсвэрийг шийдвэрлэн ариун цэвэр болон хог хаягдлын байгууламж, тохижилт бүтээн байгуулалтын ажлуудыг гүйцэтгэж төслийн талбайд 58,000 ширхэг мод тарих ажлыг зохион байгууллаа. Төслийн талбайд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, “Амьд хөгжмийн наадам” ТББ хамтран “Плэйтийм-2024” олон улсын хөгжмийн наадмыг 2024 оны 07 дугаар сарын 04-07-ны өдрүүдэд зохион байгуулж гадаадын 21 улсын 52 хамтлаг, дуучид, Монгол Улсаас 250 гаруй хамтлаг дуучид нийт 800 гаруй хамтлаг, уран	90

Д/д	Үйл ажиллагаа, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Суурь түвшин, үр дүнгийн үзүүлэлт (2020 он)	Хүрсэн түвшин, үр дүн (2024 он)	Хувь
					бүтээлчид 4 өдрийн турш 15 тайзнаас уран бүтээлээ хүргэж арга хэмжээг гадаад, дотоодын 71,000 гаруй хүн үзэж сонирхсон. Наадмын үеэр болон бэлтгэл ажилд 4000 гаруй түр ажлын байр бий болгож, 200 жижиг дунд бизнес эрхлэгч, аж ахуй нэгж, байгууллага худалдаа үйлчилгээ зохион байгуулж, эдийн засагт 8,0 гаруй тэрбум төгрөгийг эргэлтэд оруулсан байна.	

ТАНИЛЦСАН
ДАРГА



Д.БАТСҮХ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА,
ДАРГА

САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН

Д.ТАНБОЛД

НЭГТГЭСЭН:

БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ТАЙЛАН, ТОГТООЛ ШИЙДВЭР,
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭВЭГЖИЛТ ХАРИУЦСАН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

О.НЯМБАТ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

СУРГАЛТ, СУДАЛГАА, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН

МЭРГЭЖИЛТЭН Ч.ЭНХ-ОТГОН